



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН, ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Ц.ДАВААСҮРЭН
ТАНАА

2025. 03. 28 № 1267
танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-т "Монгол Улсын Ерөнхий аудитор төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны жилийн тайланг хуульд заасан хугацаанд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ" гэж заасны дагуу Төрийн аудитын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны тайлан, Үндэсний аудитын газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудиторын дүгнэлт, Төрийн аудитын байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд хийсэн системчилсэн үнэлгээний тайланг тус тус хүргүүлж байна.


Д.ЗАГДЖАВ



ӨМНӨХ ҮГ

Төрийн аудитын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Монгол Улсын Ерөнхий аудитор төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны жилийн тайланг хуульд заасан хугацаанд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ” гэж заасны дагуу Монгол Улсын Төрийн аудитын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны тайланг, 2024 оны санхүүгийн тайланд хараат бус аудитын хуулийн этгээдийн гаргасан дүгнэлтийн хамт Та бүхэнд өргөн барьж байна.

Төрийн аудитын байгууллага хуулиар хүлээсэн төрийн санхүү, төсөв, нийтийн эрх ашгийн төлөө гүйцэтгэх засаглалын хүлээх хариуцлага, төрийн байгууллагуудын зохион байгуулалт, үйл ажиллагааны үр нөлөө, хөрөнгийн захиран зарцуулалтад тавих хяналтын чиг үүргээ Үндсэн хуулиар олгогдсон хууль дээдлэх, шударга ёсыг хангах, ил тод, нээлттэй, бодитой байх төрийн аудитын үндсэн зарчмыг удирдлага болгон гүйцэтгэл, нийцэл болон санхүүгийн аудитыг гүйцэтгэж байна.

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр тогтоолыг үндэслэн Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг баталж, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч 3, Үндэсний аудитын газрын зохион байгуулалтын бүтцийн 8 газар, 22 аймаг нийслэл дэх Төрийн аудитын газарт нийт 508 албан хаагч ажиллаж байна.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос баталсны дагуу 2024 онд хуулийн дагуу 28, бодлогоор 5 сэдвийн хүрээнд Үндэсний аудитын газар, Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаалаар 18 сэдвийн хүрээнд 2024 онд нийт 3,823 аудитыг гүйцэтгэж, 9629 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлснээс гадна улс, орон нутгийн төсөвт 43.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага хуулиар тодорхойлсон чиг үүргийнхээ дагуу улс, орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн 6,831 санхүүгийн тайланд аудит хийснээс 3,539 санхүүгийн тайланд бие даасан аудитын дүгнэлт, 3,292 байгууллагад аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн байна.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 5,109.3 тэрбум төгрөгийн алдааг илрүүлж, шалгагдагчийн санхүүгийн тайлан дахь алдааг аудитын явцад залруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, хамгаалалт, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөвлөх чиг үүргийг үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллалаа.

Мөн Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуультай холбогдсон аудитыг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг тухай бүр шинэчлэн баталж, сонгуулийн үйл явцад хууль тогтоомжоор хүлээсэн аудит хийх чиг үүргээ хариуцлагатай хэрэгжүүлж, аудитын тайлан дүгнэлтийг тогтоосон хугацаанд олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлж, Монгол Улсын хууль тогтоох дээд байгууллага болон орон нутгийн Хурлын сонгуулийн 2024 оны үйл ажиллагааг амжилттай явагдахад зохих хувь нэмрээ оруулсныг онцлон тэмдэглэж байна.

Төрийн аудитын байгууллага 2024 онд гүйцэтгэсэн аудитынхаа үр нөлөөг сайжруулж, аудитын сэдэв сонголт, үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрийг оновчтой хэрэгжүүлж, улс орны хөгжлийн шаардлагатай хөл нийлүүлэн мэдээллийн технологийн ололтыг ашиглан аудиторудынхаа мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх, аудитын шийдвэрийн хэрэгжилт, үр өгөөжийг харилцагч талуудтайгаа хамтран сайжруулахад идэвх, санаачилгатай, үр бүтээлтэй, хариуцлагатайгаар үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллалаа.

Төрийн аудитын байгууллагын хуулиар хүлээсэн төрийн санхүү, төсвийн хяналтын чиг үүрэг, төрийн аудитын үйл ажиллагааны гүйцэтгэлийг Улсын тогтвортой хөгжилд хувь нэмэр болохуйц үр дүнд хүргэхийн төлөө хичээнгүйлэн хөдөлмөрлөсөн Төрийн аудитын байгууллагын албан хаагчид болон бидний ажлыг дэмжсэн харилцагч талууд Та бүхэнд талархал илэрхийлж байна.

**Монгол Улсын
Ерөнхий аудитор**



**Дэлэгийн
Загджав**

АГУУЛГА

Төрийн аудитын байгууллагын 2024 оны үр дүн	9
2024 оны онцлох үйл ажиллагаа	10

БҮЛЭГ 1. ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА	12
Төрийн аудитын байгууллагын стратеги	14
Төрийн аудитын байгууллагын 2024 оны зорилт	14
Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалт, хүний нөөц	15
Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	19
Төрийн аудитын стандарт, арга зүй	20

БҮЛЭГ 2. 2024 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	22
Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудит, түүний хэрэгжилт, үр өгөөж	24
Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэсэн аудит	32
Төрийн аудитын чанарын баталгаажуулалт	68

БҮЛЭГ 3. ТӨРИЙН АУДИТЫГ ДЭМЖИХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ	70
Захиргааны үйл ажиллагаа, санхүү, төсвийн гүйцэтгэл	72
Ил тод байдал	76
Хууль эрх зүй	78
Сургалт хөгжил	79
Судалгаа, шинжилгээ	82
Мэдээллийн технологи	84
Харилцаа, хамтын ажиллагаа	86
Хяналт-шинжилгээ, үнэлгээ	88
Эрсдэлийн удирдлага	88
Дотоод аудит	89

БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ	90
Дүгнэлт	92

БҮЛЭГ 5. 2025 ОНЫ ЗОРИЛТ	94
Төрийн аудитын байгууллагын 2025 оны зорилт	96

ХАВСРАЛТ	98
Хараат бус аудиторын дүгнэлт	100
2024 оны үйл явдлын товчоон	102

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНТАГ	Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газар
АДБ	Аудитын Дээд Байгууллага
Аи Ди Аи	ИНТОСАИ-н Хөгжлийн санаачилга
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНТУ	Бүгд Найрамдах Турк Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
ГХГЗЗГ	Газрын харилцаа, геодези зураг зүйн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ИНТОСАИ	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Байгууллага
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЕАО	Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч
НДС	Нийгмийн даатгалын сан
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАГ	Төрийн аудитын газар
ТБХ	Төсвийн байнгын хороо
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТОСК	Төрийн орон сууцны корпораци
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УТЕЗ	Улсын төсвийн ерөнхийлөн захирагч
УТҮГ	Улсын төсвийн үйлдвэрийн газар
УИХ	Улсын Их Хурал
УУХҮС	Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд
ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
ҮАГ	Үндэсний аудитын газар
ШДНЦХ	Шилэн дансны нэгдсэн цахим хуудас
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан

АЛСЫН ХАРАА

Монгол Улсын хөгжлийн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн өндөр үр нөлөөтэй төрийн аудитыг гүйцэтгэж, арга зүй, технологи, үйл ажиллагаагаар бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх аудитын дээд байгууллага болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлж, харилцагч талуудын хамтын ажиллагааг сайжруулах замаар иргэдийн амьдралыг сайжруулна.

ЭРХЭМЛЭХ ҮНДСЭН ЗАРЧМУУД



ХУУЛЬ ДЭЭДЛЭХ



ИЛ ТОД, БОДИТОЙ БАЙХ



МЭРГЭШСЭН БАЙХ



ХАРААТ БУС, БИЕ ДААСАН БАЙХ



ШУДАРГА ЁСЫГ ХАНГАХ



МЭДЭЭЛЛЭЭР БҮРЭН ХАНГАГДАХ



ТӨРИЙН АУДИТЫН ОЛОН УЛСЫН
НИЙТЛЭГ СТАНДАРТАД НИЙЦЭХ

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ҮР ДҮН

3,823

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ



132

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

3,540

САНХҮҮГИЙН АУДИТ

151

НИЙЦЛИЙН АУДИТ



9,629

Зөвлөмж



Залруулсан алдаа

5,109.3

 тэрбум төгрөг

Албан шаардлага

6,389



Төлбөрийн акт

2,418




Хүлээн зөвшөөрүүлсэн
үр өгөөж

1,730.5

 тэрбум төгрөг

27

Асуудал хууль хяналтын
байгууллагад шилжүүлсэн



257

Албан тушаалтанд
хариуцлага тооцуулсан



Санхүүгийн бус үр өгөөж

1,053




Нэг төгрөгт ногдох
санхүүгийн үр өгөөж

41.3

 төгрөг

Улс, орон нутгийн төсөвт
төвлөрүүлсэн орлого

43.7

 тэрбум төгрөг

93

Нийт сургалт



508

Нийт албан хаагч

2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллагаас шинээр гаргасан аудитын удирдамжуудыг төрийн аудитын үйл ажиллагаанд нэвтрүүлж байна.

АДБОУБ-аас боловсруулан гаргасан “Төрийн худалдан авах ажиллагаанд аудит хийх” УДИРДАМЖ 5280, “Улсын өрийн мэдээллийн системүүд” УДИРДАМЖ 5259, “Гамшгийн удирдлагад аудит хийх” УДИРДАМЖ 5330 эмхэтгэлүүдийг орчуулан, хэвлүүлж Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн аудит хийх чиг үүрэг бүхий аудиторруудад түгээж, холбогдох сургалтыг зохион байгуулан аудитын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.



Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-д төрийн аудитын төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын өрийн тайлан, засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, Засгийн газар, Улсын Их Хуралд хүргүүлэх гэж заасны дагуу хуулийн хугацаанд нь санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэлээ.

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд тус тус заасны дагуу улсын болон орон нутгийн төсвийн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 6831 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулж, 3292 санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, 3539 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, санхүүгийн тайлан дахь 5,109.3 тэрбум төгрөгийн алдааг заруулж төсвийн санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөвлөх чиг үүргийг үр нөлөөтэй хэрэгжүүлж, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг Улсын их хурал болон холбогдох байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлээ.



Монгол Улсын хөгжлийн бодлого, үйл ажиллагааны баримт бичгийн хэрэгжилт, гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах чиг үүргийн хүрээнд засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны тогтоолын дагуу Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлд аудит хийхэд хөтөлбөрт оролцогч талуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, арга хэмжээнд шаардлагатай төсөв хөрөнгө нь батлагдаагүйгээс тухайн зорилт, арга хэмжээний хэрэгжилт зорилтот үр дүнд хүрээгүй, хөтөлбөрийн биелэлт 70.5 хувьтай байна. Аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдад 4, Төсвийн ерөнхийлөн захирагчид болон хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагад 3 зөвлөмж хүргүүлээ.



Монгол Улсын Их Хурлын болон Орон Нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуультай холбоотой аудит хийж, дүгнэлт гаргав.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу нэр дэвшигч, нам, эвслийн зардлын дээд хэмжээг тогтоох, мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах, хандивын тайлан, сонгуулийн зардлын тайланг баталгаажуулах аудитыг хуулийн хугацаанд гүйцэтгэж, аудитын тайлан дүгнэлтийг тухай бүр олон нийтэд мэдээлсэн.



Ази, номхон далайн бүс нутгийн аудитын дээд байгууллагуудын гүйцэтгэлийн аудитыг сайжруулах төслийг үр дүнтэй хэрэгжүүлж байна.

ИНТОСАИ-н Хөгжлийн санаачилга (Аи Ди Аи)-гаас хэрэгжүүлж буй “Тогтвортой гүйцэтгэлийн аудитын сайн практик” төслийн II шатны төлөвлөгөөний хүрээнд Монгол Улсын Үндэсний аудитын газрын хийж буй гүйцэтгэлийн аудитад Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартын хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллаж буй байдалд үнэлгээ хийж, жилийн аудитын төлөвлөлтийн талаар интерактив мэргэжлийн боловсролын модулиудыг бий болгож, гүйцэтгэлийн аудитыг хэрэгжүүлэгч аудиторын чадамжийн хүрээний төслийг боловсруулсан байна.



“Оюутолгой төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажууллаа.

“Оюутолгой төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг хэрэгжүүлж, тайланг УИХ-ын Төсвийн байнгын хороонд хүргүүлж, хэлэлцүүлээ.



Чанарын менежментийн тогтоолцооны стандарт (ISO9001:2015)-ыг бүрэн нэвтрүүлж, 2 дахь шатны баталгаажуулалтад амжилттай хамрагдлаа.

Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартыг Үндэсний аудитын газрын хэмжээнд нэвтрүүлж, чанарын менежментийн тогтолцооны стандартыг байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшил болгон бэхжүүлэх ажлыг тогтмол хэрэгжүүлэн тайлагнаж, Франц Улсын баталгаажуулалтын байгууллага “Афнор” группийн 2 дахь шатны аудит, баталгаажуулалтад амжилттай хамрагдан гэрчилгээ гардан авсан.

БҮЛЭГ 1

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

Төрийн аудитын байгууллагын стратеги
Төрийн аудитын байгууллагын 2024 оны зорилт
Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалт, хүний нөөц
Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
Төрийн аудитын стандарт, арга зүй

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг хараат бусаар явуулах эрх зүйн болоод арга зүй, технологийн таатай орчныг бүрдүүлнэ.

ЗОРИЛТ 1:

Төрийн аудитын байгууллагын хараат бус байдал, хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх;

ЗОРИЛТ 2:

Төрийн аудитын тогтолцоонд арга зүй, стандартын шинэчлэлийг хийж, олон улсын чиг хандлагад нийцсэн дэвшилтэт технологи бүхий орчин үеийн төрийн аудитын тогтолцоог төлөвшүүлэх;

ЗОРИЛТ 3:

"Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030"-ыг хэрэгжүүлэх төрийн аудитын байгууллагын идэвх оролцоог нэмэгдүүлэх замаар сайн засаглалыг дэмжих;

ЗОРИЛТ 4:

Харилцагч талуудын үр ашигтай хамтын ажиллагааг дэмжиж, аудитын чанар, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэх;

ЗОРИЛТ 5:

Нийгмийн бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээний асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх;

ЗОРИЛТ 6:

Төрийн аудитын байгууллагын дотоод засаглал, дэмжих үйлчилгээ, эрсдэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх.

ТУХАЙН ЖИЛИЙН ЗОРИЛТ

2024 ОН


"АУДИТЫН ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД
ХАРИЛЦАГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООГ
САЙЖРУУЛАХ"

2025 ОН

"ЧАДАМЖИД СУУРИЛСАН
ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫГ
ТӨЛӨВШҮҮЛЭХ"



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ



Монгол Улсын Ерөнхий аудиторов 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/76-1 дүгээр тушаалаар “Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратеги”-ийг баталж, хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ хийх замаар өнгөрсөн 6 жилд дэвшүүлсэн дунд хугацааны зорилтоо хангалттай биелүүллээ.

Төрийн аудитын байгууллага бодлогын тасралтгүй, үр нөлөөтэй залгамжийг хадгалах үүднээс “Төрийн аудитын байгууллагын 2025-2030 оны стратегийн баримт бичиг”-ийн төслийг хууль тогтоомж, стандарт, бодлого, зорилтод нийцүүлэн боловсруулах үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг Монгол Улсын Ерөнхий аудиторов А/78 тушаалаар баталж, ажлын төлөвлөгөөний дагуу стратегийн баримт бичгийн төслийг 4 үе шаттайгаар бэлтгэсэн.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ЗОРИЛТ

Аудитын үр дүнд бий болох үр өгөөжийг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн 2024 онд **“АУДИТЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД ХАРИЛЦАГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООГ САЙЖРУУЛАХ”** зорилтыг дэвшүүлэн ажилласан. Зорилтын дагуу дараах хөтөлбөр, арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Тухайлбал;


- Төрийн аудитын тайланг харилцагч талууд болон иргэд, олон нийтэд ил тод нээлттэй мэдээлж, зарим аудитын тайлан, дүгнэлтийг Улсын Их Хурал болон холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахад харилцагч талуудтай идэвхтэй хамтран ажиллалаа.
- Төрийн аудитын байгууллагын бодлого шийдвэр, үйл ажиллагаа болон гүйцэтгэсэн аудитын тайлан, холбогдох шийдвэрийн хэрэгжилтийн талаар телевизийн ярилцлага-15, видео мэдээ-20, сонин, сайтын мэдээ-228, телевизийн мэдээ-34, сонин болон сайтын ярилцлага-16 бэлтгэж, харилцагч талууд, иргэд олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлсэн.
- Улс, орон нутгийн ээлжит сонгууль зохион байгуулагдсантай холбогдуулан сонгуулийн зардлын дээд хэмжээг тогтоож, улс төрийн намууд, нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланг баталгаажуулж, нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянаж дүгнэлт гаргаж, хуульд заасан хугацаанд олон нийтэд мэдээлсэн.
- Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр Австрали, БНСВУ, Унгар Улс, Кувейт, Турк улсын АДБ-тай харилцах хамтын ажиллагааг сэргээж, шинэ шатанд гаргасан. ОУБ-ын төсөл, хөтөлбөрт хамрагдах арга хэмжээг өргөн хүрээнд хэрэгжүүллээ.
- ААНТАГ-т хийгдсэн аудитын үр дүнг иргэд, олон нийтэд мэдээлэх, сурталчлан таниулах, “Аудитын нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулах, аудитад хамрагдагч болон харилцагч талуудтай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ

Монгол Улсын Ерөнхий аудитор нь Төрийн аудитын тухай хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газар болон Аймаг, нийслэл дэх 22 Төрийн аудитын газрыг босоо зохион байгуулалтын бүтцээр нэгтгэн зохион байгуулж, удирддаг.

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг шинэчлэн баталсны дагуу Монгол Улсын Ерөнхий аудитор Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдөр А/51 дүгээр тушаалаар баталсан. Тушаалын дагуу Үндэсний аудитын газарт Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч 3, Үндэсний аудитын газарт зохион байгуулалтын бүтцийн 8 нэгж, нийт 194 албан хаагч ажиллаж байна.

Үндэсний аудитын газрын зохион байгуулалтын бүтэц




Төрийн аудитын байгууллагын хэмжээнд үйл ажиллагааны бүхий л чиглэлийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бууруулах чиг үүрэг бүхий Эрсдэлийн удирдлагын газрыг шинээр, Үндэсний аудитын газар, Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газарт дэмжих чиг үүрэг бүхий шинжээч /нягтлан бодогч, бичиг хэрэг дотоод ажил хариуцсан/-ийн орон тоог тус тус бий болгосон.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу Төрийн аудитын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо байгуулагдан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар Нийслэл дэх Төрийн аудитын газарт 4 хэлтэс 61 албан хаагч, 21 аймаг дахь Төрийн аудитын газарт 324 албан хаагч тус тус ажиллахаар шийдвэрлэсэн.

Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрын зохион байгуулалтын бүтэц



Төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн бодлого, удирдлагын хүрээнд төрийн албан хаагчийн шатлан дэвших зарчмыг баримтлан албан тушаалд дэвшүүлэн 18, байгууллагын нэгж хооронд ижил ангиллын албан тушаалд шилжүүлэн 19, төрийн өөр байгууллагаас шилжүүлэн 13, төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөөс 86, албан тушаалыг түр орлон гүйцэтгүүлэхээр 29, нийт 165 иргэн, албан хаагчийг албан тушаалд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн томилсон.

Төрийн аудитын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 2024 онд 6 удаа зохион байгуулж байгууллага дотроо болон төрийн өөр байгууллага, төрийн жинхэнэ албаны нөөцөөс нийт 169 албан хаагч, иргэнийг сонгон шалгаруулалтад хамруулж, 99 албан хаагч, иргэнийг тухайн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн тангараг өргөх ёслолыг Төрийн албаны тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулна." гэж заасны дагуу Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн тангараг өргүүлэх ёслолын ажиллагааг тухай бүр зохион байгуулсан.

Тайлант 2024 онд Үндэсний аудитын газар 186, Нийслэл дэх Төрийн аудитын газар 56, аймаг дахь Төрийн аудитын газар 266, нийт Төрийн аудитын байгууллагын хэмжээнд 508 албан хаагчидтай үйл ажиллагаагаа явуулсан.




Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн тангараг

Төрийн аудитын байгууллагын ажилтан би хөндлөнгийн аливаа нөлөөнд үл автан, гагцхүү хуульд захирагдан үйл ажиллагаагаа явуулж, төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая. Тангаргаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.


Боловсролын зэргээр авч үзвэл: Нийт албан хаагчийн 0.4 хувь нь доктор, 44.9 хувь нь магистр, 50.8 хувь нь бакалавр, 1.8 хувь нь тусгай дунд, 2.2 хувь нь бүрэн дунд боловсролтой албан хаагч байна.

Боловсролын зэрэг



Мэргэжлийн хувьд авч үзвэл: Нийт албан хаагчийн 70.9 хувь нь санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засагч, 10.8 хувь нь эрх зүйч, 5.5 хувь нь инженер, 12.8 хувь нь бусад мэргэжлийн албан хаагч байна.


Мэргэжил



Албан хаагчдыг ажилласан жилийн байдлаар авч үзвэл: 0-5 жил 237 буюу 46,6 хувь, 6-10 жил 105 буюу 20,7 хувь, 11-15 жил 96 буюу 18,9 хувь, 16-аас дээш жил ажилласан 70 буюу 13,8 хувийг тус тус эзэлж байна. Нийт албан хаагчийн 53,4 хувь нь 6 болон түүнээс дээш жил төрийн аудитын байгууллагад ажиллаж байгаа нь тус байгууллагын хүний нөөцийн тогтвор суурьшил, мэргэшсэн байдал, залгамж чанарыг хадгалах зарчмыг хэрэгжүүлж буйг харуулж байна.

Хүний нөөцийг насны байдлаар авч үзвэл: Нийт албан хаагчийн 9.8 хувь нь 30 хүртэл насны, 35 хувь нь 30-39 насны, 33,7 хувь нь 40-49 настай, 21,5 хувь нь 50-аас дээш насны албан хаагчид байна.

Төрийн аудитын байгууллагын хүний нөөц (хүйс, насны бүлгээр)



“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, мод тарих ажлыг зохион байгуулаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын дагуу тайлант онд Үндэсний аудитын газрын хамт олон Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 40 гаруй суулгац мод шинээр тарьж, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрууд тухайн орон нутагтаа “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, мод тарих ажилд идэвхтэй оролцлоо.



Төрийн аудитын байгууллагын дэргэдэх Ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжиж, ахмадуудын дунд нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулаа.

Ахмадын хорооны төлөөлөл Монгол Улсын Ерөнхий аудитортой уулзан санал хүсэлт тавьж, цаашдын ажлын талаар ярилцлаа. Ахмадын өдрийг тохиолдуулан Тамгын даргын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн Б/33 дугаар тушаалаар Төрийн аудитын байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан 207 ахмадад хүндэтгэл үзүүлж, ахмадын баяртай холбогдуулан 31 ахмадын аяллыг амжилттай зохион байгуулаа.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 46 дугаар тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Төрийн аудитын байгууллагын 2024 онд хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг түүвэрлэн нэгтгэх, холбогдох зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн чиг үүрэгт хуваарилах, гүйцэтгэлийг хангуулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн, тайлагнаж ажиллалаа.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу 2024 оны ээлжит сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээг тогтоох, мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах, хандивын тайлан, сонгуулийн зардлын тайланг баталгаажуулах аудитыг гүйцэтгэж, хөтөлбөрт заасны дагуу тайлан дүгнэлтийг хуулийн хугацаанд нь олон нийтэд ил тод нээлттэй мэдээллээ.

Мөн сонгуультай холбоотой аудитын журам, заавар, аргачлалуудыг шинэчлэн боловсруулж, Сонгуулийн ерөнхий хороотой хамтран танилцуулах сургалтуудыг тухай бүр зохион байгуулсан. Сургалтын мэдээ материалыг цахимжуулж, сургалт хөгжлийн системийн "Хөгжлийн сургалт" талбарын "Аудитын 5 минут"-д байршуулан нийт алба хаагчдад хүргэсэн. Төрийн аудитын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл болон мөн хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн баталгаажсан санхүүгийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын тайланг open.audit.mn портал сайтад ил тод байршуулж, тайлангийн дүн дүгнэлтийг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан олон нийтэд түгээх ажлыг зохион байгууллаа.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8-р дугаар зүйлд заасны дагуу төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох чиг үүргийн дагуу байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллүүдийг <https://audit.mn/>, <https://open.audit.mn/> цахим хуудаст тухай бүр байршуулж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэх тухайн жилийн аудитын сэдвийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог хангах, мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх зорилгоор "Нээлттэй аудит" портал сайтад "ИРГЭДИЙН ОРОЛЦОО" хэсэгт аудитын сэдвийн талаар болон хэрэгжүүлж буй аудиттай холбоотой санал авах цонхыг идэвхтэй ажиллуулж саналыг нэгтгэн 2025 онд гүйцэтгэх аудитын сэдэвт тусган, улмаар УИХ-ын Төсвийн байнгын хороогоор хэлэлцүүлэн батлуулж, тогтоолыг audit.mn цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод мэдээлсэн.

ХАСХОМ мэдүүлгийг хуулийн хугацаанд 431 албан хаагчаас гаргуулан авч нэгтгэн тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.4, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.5-т заасны дагуу томилогдсон, хөрөнгө орлогод өөрчлөлт орсон 50 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан авч, шинээр болон шилжин томилогдсон 117 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргуулж, мэдээлж ажиллалаа.

Төрийн аудитын байгууллага нь Авлигын эсрэг хуулийн хүрээнд Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг хангаж, тогтмол тайлагнасан.

ТӨРИЙН АУДИТЫН СТАНДАРТ, АРГА ЗҮЙ

Төрийн аудитын байгууллага нь аудитын бодлого, журам, заавар, аргачлалыг Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын шинэчлэл, өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэн боловсруулан баталгаажуулж, нутагшуулах, аудитад ашиглах арга зүйг төлөвшүүлэх ажлыг тасралтгүй хэрэгжүүлдэг.

Төрийн аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэх, үүрэг хариуцлагыг сайжруулах, аудитын бодлого, аудитын арга зүйг олон улсын түвшинд хүргэх зорилгоор АДБОУС, удирдамж, гарын авлагыг эх хэлнээ буулгах, хянан баталгаажуулж эмхэтгэн аудитын үйл ажиллагаанд мөрдөж байна.



Гамшгийн удирдлагад аудит хийх-УДИРДАМЖ 5330:

Энэхүү удирдамж нь гамшгийн удирдлагад аудит хийх үед Аудитын дээд байгууллагуудад заавар өгөх зорилготой баримт бичиг юм.

Төрийн худалдан авах ажиллагаанд аудит хийх-УДИРДАМЖ 5280:

Энэхүү удирдамж нь төрийн худалдан авах ажиллагааны онцлог шалгах зүйлийг ойлгож, холбогдох АДБОУС-ыг тэр хүрээнд мөрдөхөд туслах зорилготой баримт бичиг юм.

Улсын өрийн мэдээллийн системүүд-УДИРДАМЖ 5259: Энэхүү удирдамж нь улсын өрийн удирдлагын мэдээллийн системүүдийн ерөнхий болон нарийвчилсан хяналтыг үнэлэх аудитад ашиглаж болох баримт бичиг юм.

Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллагын ХИҮ их хурлаар ИНТОСАИ-н үр нөлөө, хүртээмжийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд бүх байгууллага, бүс нутгийн байгууллага, гадаад түншүүд, харилцагч талуудыг татан оролцуулахыг уриалж, аудитын дээд байгууллагууд шударга, хүртээмжтэй, хэнийг ч орхигдуулахгүй хамтран ажиллаж, бидний амжилт нь харилцагч талуудын хичээл зүтгэл, тууштай хамтын ажиллагаанаас хамаарахыг онцолж Риогийн тунхаглалыг баталсан. Тус тунхаглалыг монгол, англи хэл дээр хэвлүүлэн нийт албан хаагчдад сурталчлан таниулах зорилгоор видео хичээл бэлтгэсэн ба Төрийн аудитын сургалт, хөгжлийн системийн хөгжлийн талбарт байршуулснаас гадна танхимын сургалт хийв.



Аудитын зөвлөмжийг тодорхой, бодитой, хэмжигдэхүйц, чанартай боловсруулах, баталгаажуулахад онцгой анхаарч, "Зөвлөмж боловсруулах аргачлал"-ыг бэлтгэн нийт албан хаагчдад сургалт зохион байгуулсан нь аудитын тайлагналын үе шатанд ашиглах чухал зааварчилгаа боллоо.

Цаг үеийн хэрэгцээ шаардлагаар Монгол Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт болон Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан дараах заавар, аргачлалыг батлан хэрэгжүүлсэн байна.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Зөвлөмж боловсруулах аргачлал



Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргах аргачлал;
(МУЕА-ын 2024 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/23 дугаар тушаал)

Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах заавар;
(МУЕА-ын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/24 дүгээр тушаал)

Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам;

(МУЕА-ын 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/44 дугаар тушаал)

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргах аргачлал;

(МУЕА-ын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/49 дугаар тушаал)

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж дүгнэлт гаргах заавар;

(МУЕА-ын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/49 дугаар тушаал)

Сонгуулийн аудитуудын төлөвлөлтийн үе шатны ажилд сонгуулийн тухай хууль болон холбогдох заавар, журмын хэрэглээний талаар аудитыг гүйцэтгэх баг бүрэлдэхүүнд "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, түүний нэмэлт, өөрчлөлт, онцлог зохицуулалт болон сонгуулийн мөрийн хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага, хугацаа зэрэг холбогдох нэмэлт асуудлууд" сэдвээр Сонгуулийн ерөнхий хороотой хамтран танхимын сургалт зохион байгуулж, мөн "Сонгуулийн тухай хууль тогтоомж" сэдэвт хичээлийг бэлтгэн орон нутаг дахь Төрийн аудитын газрын нийт албан хаагчдад заасан.

БҮЛЭГ 2

2024 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудит, түүний
хэрэгжилт, үр өгөөж
Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэсэн аудит
Төрийн аудитын чанарын баталгаажуулалт





САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шалгадагч этгээд санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж баталгаажуулна.



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Шалгадагч этгээдийн бодлого, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний гүйцэтгэл нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй эсэхэд аудит хийж, тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргана.




НИЙЦЛИЙН АУДИТ

Шалгадагч этгээд үйл ажиллагаандаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын нийцэлд аудит хийж, тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргана.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ӨГӨӨЖ


Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос баталсан сэдвийн хүрээнд 2024 онд хуулийн дагуу 28, бодлогоор “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө”, “Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө”, “Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого түүний хэрэгжилт, үр дүн”, “Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологийн судалгааны ажлын хэрэгжилт, үр дүн”, “Монгол Улсын Засгийн газраас хог хаягдлын талаар баримталж буй үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, үр нөлөө” зэрэг 5 сэдвийн хүрээнд Үндэсний аудитын газар, Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаалаар 18 сэдвийн хүрээнд орон нутаг дахь Төрийн аудитын газрууд санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудит хийж, Төрийн аудитын байгууллага 2024 онд нийт 3,823 аудитыг гүйцэтгэж тайлан, дүгнэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ.

Гүйцэтгэсэн аудит, 2024 он



Тайлант онд гүйцэтгэсэн аудитын явцад нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 5,109.3 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 41,256.1 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлжээ.

Нийт илрүүлэлт, аудитын төрлөөр, тэрбум төгрөгөөр, 2024 он



Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэсэн аудитаар илрүүлсэн зөрчлийн 36.8 хувь нь санхүүгийн тайлангийн аудит, 50.0 хувь нь гүйцэтгэлийн аудит, 13.2 хувь нь нийцлийн аудитаар илэрсэн байна.

Төрийн аудитын байгууллага нь аудитын илрүүлэлтийг алдаа, зөрчлийг дараах байдлаар авч үздэг. Алдааг аудитын явцад залруулж болдог бол зөрчилд холбогдох шийдвэрлэлтийг хийдэг.



Төрийн аудитын байгууллага тайлант онд аудит хийх явцдаа математик тооцоолол алдсан, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг буруу хэрэгжүүлсэн, мэдээллийг тусгаагүй мөн буруу тусгаж илэрхийлсэн зэрэг нийт 5,109.3 тэрбум төгрөгийн алдааг илрүүлэн, шалгагдагч этгээдийн санхүүгийн тайланд залруулга хийлээ.

Нийт залруулсан алдааны 2,430.9 тэрбум төгрөг буюу 47.6 хувь нь буруу тусган илэрхийлсэн алдаа байсан бол 34.1 хувь буюу 1,742.8 тэрбум төгрөгийн алдаа нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой алдаа байсан байна. Тайлант хугацаанд гүйцэтгэсэн аудитаар зөрчлийг илрүүлэх замаар улс, орон нутгийн төсөвт 43.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Залруулсан алдаа гэж юу вэ?



Санхүүгийн тайлан дахь ямар нэгэн дүн, тодруулгыг орхигдуулах, буруу тусган илэрхийлсэн алдаатай илэрхийллийг санхүүгийн тайланд зөв дүнгээр илэрхийлж, орхигдуулсан дүн, тодруулгыг буцаан оруулж залруулсан бол залруулсан алдаа гэж үздэг.


Яагаад залруулга чухал вэ?



Санхүүгийн тайланд хөрөнгийн ажил гүйлгээ болон үлдэгдлийг тусгахгүй орхигдуулсныг залруулснаар харилцагч талуудыг бодит мэдээллээр хангахад чухал үр нөлөөтэй бөгөөд аудитын үр өгөөж бий болох юм.

Алдаа нь санхүүгийн тайлангийн элементүүдийн хүлээн зөвшөөрөлт, хэрэгжилт, тодруулгатай холбоотой үүсдэг. Үүнийг нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой алдаа гэж үздэг бол Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн үйлдлийг зөрчилд тооцдог.

Залруулсан алдаа, алдааны ангиллаар, тэрбум төгрөгөөр



Нийт 5,109.3 тэрбум төгрөг

Төрийн аудитын байгууллага улс, орон нутгийн төсвийн төлөвлөлт, түүний орлого, зарлагын гүйцэтгэл, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хэрэгжүүлж байгаа төсвийн эх үүсвэрийн дэмжлэгтэй төсөл, хөтөлбөрийн явц, үр дүнд хийж байгаа зарим аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн зөвлөмж, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг нягтлан тайлагнаж санхүү, чанарын үр нөлөөг сайжруулахад анхаарч 2024 онд “Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад харилцагч талуудын оролцоог сайжруулах” зорилтыг дэвшүүлж, зөрчлийг илрүүлэн дараах байдлаар шийдвэрлэлт хийлээ. Үүнд:

- 7,355.6 тэрбум төгрөгийн зөрчилд 9,629 зөвлөмж¹;
- 33,319.7 тэрбум төгрөгийн зөрчилд 6,389 албан шаардлага²;
- 475.2 тэрбум төгрөгийн зөрчилд 315 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага³;
- 76.3 тэрбум төгрөгийн зөрчилд 2,418 төлбөрийн акт⁴;
- 29.3 тэрбум төгрөгийн зөрчилд 27 гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй үйлдлийг прокурорын байгууллагад шилжүүлээ⁵.

Санхүүгийн тайлангийн аудитаар 3,539 байгууллагын санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийн 2,961 буюу 83.9 хувь нь өөрчлөлтгүй, 535 буюу 15.0 хувь нь хязгаарлалттай, 26 сөрөг, 17 тайланд дүгнэлт гаргахаас татгалзсан байна. Санхүүгийн аудитаар 2024 онд нийт 5,109.3 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 20.9 тэрбум төгрөгийн төлбөрийн акт, 4,463.4 тэрбум төгрөгийн зөрчилд албан шаардлага, сахилгын шийтгэл ногдуулах 282 албан шаардлага, 7994 зөвлөмж, 15 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлжээ.

Гүйцэтгэл, нийцлийн аудитаар 2024 онд 55.5 тэрбум төгрөгийн зөрчилд 226 төлбөрийн акт, 28,856.2 тэрбум төгрөгийн зөрчилд 1111 албан шаардлага, сахилгын шийтгэл ногдуулах 33 албан шаардлага, 1635 зөвлөмж, 12 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлжээ.

¹ Төрийн аудитын байгууллага аудитын дүгнэлтэд тулгуурлан төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актын хүрээнд нийтийн өмчийг төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулах үйл ажиллагааны арвилан хэмнэлт, үр ашигтай, үр нөлөөтэй байдал болон төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зорилгоор шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтанд зөвлөмж өгнө.

² Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгнө.

⁴ Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.

⁵ Аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор энэ тухай прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлнэ.

Аудитын шийдвэр /тоо, төрлөөр/

Зөрчлийн төрөл	Өмнөх оны үлдэгдэл			Тайлант он		
	Илрүүлэлт	Хэрэгжилт	Хэрэгжилт хувь	Илрүүлэлт	Хэрэгжилт	Хэрэгжилт хувь
	/Тоо/	/Тоо/		/Тоо/	/Тоо/	
Зөвлөмж	1958	1439	73.4%	9629	7245	75.2%
Төлбөрийн акт	798	309	38.7%	2418	2136	88.3%
Албан шаардлага	1733	994	57.3%	6389	4723	73.9%
Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага	100	64	64.0%	315	257	81.5%


Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал /тоогоор/

ТАБ	Эхний үлдэгдэл	Тайлант хугацаанд шинээр шилжүүлсэн	Бүгд	Хэрэгжилт					
				Бүрэн шийдвэрлэгдсэн		Хянагдаж байгаа		Хэрэгсэхгүй болсон	
				Өмнөх оноос	Тайлант оноос	Өмнөх оноос	Тайлант оноос	Өмнөх оноос	Тайлант оноос
Нийт	39	27	66	2		17	21	20	6

Төрийн аудитын тухай хуульд Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн дараах зохицуулалтыг тусгасан байдаг. Тухайлбал,


- Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3. "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ."
- Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5. "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ."
- Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 "..... бичигтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн талаар Ерөнхий аудиторт хариу мэдэгдэнэ."
- Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1. "Энэ хуулийн заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно."
- Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "..... төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ."

Нийт зөрчлийн дүн, зөрчлийн ангилал, хувиар, 2024 он




2024 онд гүйцэтгэсэн аудитаар нийт 41.2 их наяд төгрөгийн зөрчил илрүүлсний, 82.5 хувь нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 6.7 хувь нь төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой, 4.8 хувь нь нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 2.7 хувь нь орлого бүрдүүлэлттэй холбоотой зөрчил байна.

Илэрсэн алдаа, зөрчлийн дүнгийн эзлэх хувь, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар



Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын явцад тогтоосон нийт алдаа, зөрчлийг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал 57.0 хувь, уул уурхай, олборлолт 16.7 хувь, Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 13.1 хувь, Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 2.7 хувь, Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа 2.4 хувь, Тээвэр, агуулахын үйл ажиллагаа 2.2 хувь, Барилга 1.6 хувь, холбогдох бусад салбараас 3.2 хувь тус тус бүрдэж байна.

Тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж 2020-2024 он



Төлбөрийн акт: Төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн шалгагдагч этгээдэд 2024 онд 76.3 тэрбум төгрөгийн 2,418 төлбөрийн акт тогтоосноос 12.0 тэрбум төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 35.9 тэрбум төгрөг нийт 47.9 тэрбум төгрөгийг барагдуулсан байна. Тайлант хугацааны эцэст 825 төлбөрийн актын 286.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2024 онд гүйцэтгэсэн аудитаар нийт 76.3 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоосон бөгөөд өмнөх оноос 68.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Харин тогтоосон төлбөрийн актын хэрэгжилтийг авч үзэхэд тайлант онд тогтоосон төлбөрийн актын 15.7 хувь нь хэрэгжсэн байгаа нь өмнөх оноос хэрэгжилт 0.9 нэгж хувиар өссөн байна.

Төлбөрийн акт, ангиллаар, эзлэх дүнд:



Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын явцад тогтоогдсон төлбөрийн актын 51.2 тэрбум төгрөг буюу 67.0 хувь нь Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн, 19.1 тэрбум төгрөг буюу 25.0 хувь нь төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй, 1.5 тэрбум төгрөг буюу 2.0 хувь нь цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон, 1.4 тэрбум төгрөг буюу 2.0 хувь нь төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй, 1.3 тэрбум төгрөг буюу 2.0 хувь нь бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн, 1.6 тэрбум төгрөг буюу 2.0 хувь нь бусад зөрчил тус тус эзэлж байна.

Албан шаардлага: Тайлант онд алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх чиглэлээр 33.3 их наяд төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн бөгөөд албан шаардлагын 4.1 хувь нь хэрэгжсэн байна. Тайлант оны албан шаардлагын хувьд нийт өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүйтэй холбоотой юм. Нийт албан шаардлагын 85.5 хувийг нягтлан бодох бүртгэл, тайлагнал, хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод хяналт, хариуцлагатай холбоотой зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх чиглэлээр өгчээ.

Зөвлөмж: Төрийн аудитын байгууллага аудитын дүгнэлтэд тулгуурлан төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актын хүрээнд нийтийн өмчийг төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулах үйл ажиллагааны арвилан хэмнэлт, үр ашигтай, үр нөлөөтэй байдал болон төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зорилгоор шалгадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтанд 2024 онд нийт 9,629 зөвлөмж хүргүүлж 75.2 хувь буюу 7,245, өмнөх оноос шилжиж ирсэн 1,958 зөвлөмжийн 73.4 хувь буюу 1,439 нь тус тус хэрэгжсэн байна.

Зөвлөмж, ангиллаар, тоонд эзлэх хувь;



Нийт зөвлөмжийн 40.1 хувь нь хууль, тогтоомжийн хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналт, хариуцлагаа сайжруулах, 37.58 хувь нь орлого бүрдүүлэлттэй холбоотой буюу төсвийн орлогыг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлэн ажиллахад өгөгджээ. Эдгээр үр дүнгээс харахад эрх бүхий байгууллага, албан тушаалтан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах, дотоод хяналт, хариуцлагаа нэмэгдүүлэх чиглэлд анхаарах шаардлагатай байна.

Сахилгын шийтгэл ногдуулах: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэж заасны дагуу 2024 онд сахилгын шийтгэл ногдуулах 315 албан шаардлага, өмнөх онуудын үлдэгдэл 100 албан шаардлага, нийт 415 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагын хэрэгжилттээс урьд оны 64, тайлант оны 257 буюу 81.5 хувийн хэрэгжилттэй байна.

Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал: Тайлант онд 27 асуудал шилжүүлж, өмнөх оны үлдэгдэл 39 асуудал, нийт 66 асуудал хууль хяналтын байгууллагад хянагдаж байна. Үүнээс урьд оны бүрэн шийдвэрлэсэн 2, хяналтын шатанд 38, хэрэгсэхгүй болсон 26 асуудал байна.

Аудитын үр өгөөж: Төрийн аудитын байгууллага төсвөөс авсан санхүүжилтийн нэг төгрөг тутамд хэчнээн төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бий болгон улс, нийгэм, байгууллага, иргэдэд ашиг тус үзүүлснийг илэрхийлэх үр дүнгийн үзүүлэлт юм.



Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмж, хийсэн залруулгын дүнд шалгагдагч байгууллага өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөрөнгө, нөөцөө хэмнэсэн, үр ашгаа дээшлүүлсэн, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны чанарыг сайжруулсан бол аудитаас үр өгөөж бий болсон гэж үзнэ. Санхүүгийн үр өгөөж нь төлбөрийн акт, албан шаардлага болон зөвлөмжийг хэрэгжүүлснээр бий болсон үр өгөөж байна.

Аудитад хамрагдсан байгууллагаас 1,730.5 тэрбум төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрсөн нь төсвөөс авсан "Нэг" төгрөгийн санхүүжилт тутамд 41.3 төгрөгийн үр өгөөжийг бий болгосон байна.

Санхүүгийн үр өгөөж



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САҢХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН



Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд тус тус заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийж, “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг хүргүүлсэн.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр дамжуулан зээлдүүлсэн зээлээс олон жилийн насжилттай, хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй 1,111.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, гадаад зээлээр санхүүжүүлсэн 176.7 тэрбум төгрөгийн дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулаагүй, авлагаар бүртгээгүй, орон сууцны хороолол, дэд бүтэц төслийн хүрээнд дамжуулан зээлийн гэрээний нийт 242.8 тэрбум төгрөгийн дамжуулан зээлийн гэрээний эргэн төлөлт хийгдээгүй, гэрээний дагуу маргааныг арбитрын шүүхээр шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй, гадаад зээл, буцалтгүй тусламжаар санхүүжсэн 10 төсөл хөтөлбөрийн нийт 534.1 тэрбум төгрөгийн хөрөнгийг эзэмшигч, ашиглагч байгууллагад шилжүүлж, төслийн хаалтыг хийж, санхүүгийн тайлан бэлтгээгүй, ирээдүйн өв сангийн дансанд нийт 1,300.0 тэрбум төгрөгийн хадгаламжийг байршуулсан боловч хүүгийн орлого төвлөрүүлэх гэрээ байгуулаагүй зэргийг үндэслэн хязгаарлалттай дүгнэлт өгсөн байна.

Аудитын явцад гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийг зарим төсвийн захирагч төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээр төв төрийн сантай хоорондын тооцоо үүсгээгүйгээс Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд авлагын үлдэгдлийг 1,119.0 тэрбум төгрөгөөр илүү илэрхийлсэн, цэвэрлэх бичилт дутуу хийсэн, Монголбанкинд байрших гадаад валютын дансны хаалтын ханшийг зөрүүтэй тооцооноор мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 7.4 тэрбум төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, хуралдай бондын ханшийн залруулга 4.4 тэрбум төгрөгийг тайлагнаагүй зэрэг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой залруулга хийсэн байна.

Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн Монгол Улсын Ерөнхий сайдад 6, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 1, Сангийн сайдад 3, Барилга, хот байгуулалтын сайдад 1 зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд 72.2 хувийн биелэлттэй байна.



УЛСЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улсын төсвийн 38 ерөнхийлөн захирагч, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн тайланд аудит хийснээс 21 буюу 52.5 хувьд өөрчлөлтгүй, 19 буюу 47.5 хувьд хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Аудитад улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний 4,118 төсвийн захирагч, төрийн өмчит болон тэдгээрийн оролцоотой хуулийн этгээд, төсөл, хөтөлбөрийн нэгж санхүүгийн тайланд хамрагдахаас 2,375 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж /Өөрчлөлтгүй 2092, Хязгаарлалттай 268, Сөрөг 10, Санал дүгнэлт гаргахаас татгалзсан 5/, 1,727 санхүүгийн тайланд аудитын түүвэрт хамруулж, 16 байгууллагыг тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй, татан буугдсан зэрэг шалтгаанаар аудитад хамруулаагүй болно.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 3,367.1 тэрбум төгрөгийн алдаа илэрснээс 3,328.6 тэрбум төгрөгийн 3,279 алдааг залруулж, 38.5 тэрбум төгрөгийн 141 аудитын залруулаагүй алдаанд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн түвшинд нийт 1,883.3 тэрбум төгрөгийн 7,131 зөрчил илэрснээс 15.2 тэрбум төгрөгийн зөрчилд 1267 төлбөрийн акт тогтоож, 1,504.8 тэрбум төгрөгийн зөрчилд 2,256 албан шаардлага, 53.1 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах 100 санал хүргүүлж, 295.4 тэрбум төгрөгийн зөрчилд 3,498 зөвлөмж өгч, 14.8 тэрбум төгрөгийн 10 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлээ.

Мөн холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн асуудлаар нийт 1,490.3 тэрбум төгрөгийн 2,298 зөрчил илэрснээс 0.1 тэрбум төгрөгийн зөрчилд 32 төлбөрийн акт тогтоож, 930.2 тэрбум төгрөгийн зөрчилд 772 албан шаардлага, 164.5 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 45 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 37 санал хүргүүлж, 395.5 тэрбум төгрөгийн зөрчилд 1,457 зөвлөмж өгсөн.



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орон нутгийн төсвийн 22 ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өөрчлөлтгүй 13 буюу 59.1 хувь, хязгаарлалттай 9 буюу 40.9 хувьд /Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Увс, Сүхбаатар/ дүгнэлт өгсөн.

Аудитад орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний 2,593 төсвийн захирагч, орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсөл, хөтөлбөрийн нэгжийн тайлан, зардлын дансыг хамруулахаас 1,121 байгууллагад дүгнэлт гаргаж /өөрчлөлтгүй 851, хязгаарлалттай 245, сөрөг 15, санал дүгнэлт гаргахаас татгалзсан 10/, 1468 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан, 4 байгууллагын санхүүгийн тайланг тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй, салбар байгууллага, татан буугдсан зэрэг шалтгаанаар аудитад хамруулаагүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 478.8 тэрбум төгрөгийн алдаа илэрснээс 465.9 тэрбум төгрөгийн 2095 алдааг залруулж, 12.9 тэрбум төгрөгийн 46 залруулаагүй алдаанд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын түвшинд нийт 396.9 тэрбум төгрөгийн 4263 зөрчил илэрснээс 4.7 тэрбум төгрөгийн зөрчилд 768 төлбөрийн акт тогтоож, 281.4 тэрбум төгрөгийн зөрчилд 1605 албан шаардлага, 8.8 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 93 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 75 санал хүргүүлж, 101.9 тэрбум төгрөгийн зөрчилд 1813 зөвлөмж өгч, 0.1 тэрбум төгрөгийн 2 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүллээ.

Мөн холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн нийцлийн асуудлаар нийт 520.9 тэрбум төгрөгийн 1164 зөрчил илэрснээс 0.1 тэрбум төгрөгийн зөрчилд 48 төлбөрийн акт тогтоож, 109.9 тэрбум төгрөгийн зөрчилд 511 албан шаардлага, 322.7 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 50 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 48 санал хүргүүлж, 87.3 тэрбум төгрөгийн зөрчилд 551 зөвлөмж өгч, хууль хяналтын байгууллагад 0.9 тэрбум төгрөгийн 6 асуудлыг шилжүүллээ.



ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төрийн болон орон нутгийн төрийн өмчийн оролцоотой нийт 140 хуулийн этгээдээс 137 байгууллага аудитад хамрагдаж, тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй 3 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийгээгүй.

Аудитад хамрагдсан 137 хуулийн этгээдээс 109 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаж, 28 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. /Өөрчлөлтгүй 68, Хязгаарлалттай 38, Сөрөг дүгнэлт 3/ Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 2,183.1 тэрбум төгрөгийн 277 алдааг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын түвшинд нийт 788.0 тэрбум төгрөгийн 803 зөрчил илрүүлснээс 0.9 тэрбум төгрөгийн 89 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 661.7 тэрбум төгрөгийн 286 зөрчилд албан шаардлага, 8.7 тэрбум төгрөгийн 13 зөрчилд хариуцлага тооцох санал хүргүүлж, 0.5 тэрбум төгрөгийн 1 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 116.2 тэрбум төгрөгийн зөрчилд 414 зөвлөмж өглөө.

Мөн холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн нийцлийн асуудлаар нийт 262.5 тэрбум төгрөгийн 70 зөрчил илэрснээс, 212.2 тэрбум төгрөгийн 43 зөрчилд албан шаардлага, 38.4 тэрбум төгрөгийн 4 зөрчилд хариуцлага тооцох санал хүргүүлж, 11.9 тэрбум төгрөгийн зөрчилд 23 зөвлөмж өглөө.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайланд 12,965.6 тэрбум төгрөгийн орлого, 8,247.7 тэрбум төгрөгийн зардал, 4,717.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай тайлагнасан нь өмнөх оноос 2,155.3 тэрбум төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 75 төрийн өмчит хуулийн этгээд 5,226.3 тэрбум төгрөгийн ашигтай, 62 төрийн өмчит хуулийн этгээд 508.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.



ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орон нутгийн өмчит 428 хуулийн этгээдээс 425 байгууллага аудитад хамрагдаж, тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй болон татан буугдсан 3 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийгээгүй.

Аудитад хамрагдсан 425 хуулийн этгээдээс 188 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, 237 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргалаа. /Өөрчлөлтгүй 169, Хязгаарлалттай 55, Сөрөг дүгнэлт 7, Дүгнэлт өгөхөөс татгалзсан 6/

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 688.4 тэрбум төгрөгийн 475 алдаа илэрснээс 676.2 тэрбум төгрөгийн 457 алдааг аудитын явцад залруулж, 12.2 тэрбум төгрөгийн 18 залруулаагүй алдаанд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн түвшинд нийт 244.0 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 1.7 тэрбум төгрөгийн 140 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 219.8 тэрбум төгрөгийн 306 зөрчилд албан шаардлага, 0.7 тэрбум төгрөгийн гаргасан зөрчилд 16 албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлж, 0.1 тэрбум төгрөгийн 1 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 21.7 тэрбум төгрөгийн зөрчилд 462 зөвлөмж өглөө.

Мөн холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн нийцлийн асуудлаар нийт 42.6 тэрбум төгрөгийн 292 зөрчил илэрснээс, 0.1 тэрбум төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 28.7 тэрбум төгрөгийн 115 зөрчилд албан шаардлага, 0.4 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 7 албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлж, 0.2 тэрбум төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 13.2 тэрбум төгрөгийн зөрчилд 161 зөвлөмж өглөө.



ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БҮЙ ТӨСЛҮҮДИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй нийт 156 төсөл, хөтөлбөрөөс төсөл хөтөлбөрийн 100 нэгжийг аудитын түүвэрт хамруулж, 56 төслийн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргалаа. /Өөрчлөлтгүй 48, Хязгаарлалттай 8/

Гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх 112 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 1,224.5 тэрбум төгрөгийн төсөв батлагдаж, 65 төсөл, хөтөлбөрт 1,206.6 тэрбум төгрөгийн ашиглалт гарчээ. Тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх 37 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 570.5 тэрбум төгрөгийн төсөв батлагдаж, 28 төсөл, хөтөлбөрт 316.6 тэрбум төгрөгийн ашиглалт гарсан байна.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 271.7 тэрбум төгрөгийн 104 алдаа илэрснээс 271.4 тэрбум төгрөгийн 100 алдааг аудитын явцад залруулж, 0.3 тэрбум төгрөгийн 4 залруулаагүй алдаанд зөвлөмж өгсөн. Санхүүгийн тайлангийн түвшинд нийт 247.3 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.1 тэрбум төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт тогтоож, 188.0 тэрбум төгрөгийн зөрчилд 33 албан шаардлага, 15.2 тэрбум төгрөгийн 5 зөрчилд 5 албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлж, 44.0 тэрбум төгрөгийн зөрчилд 33 зөвлөмж өглөө. Мөн холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн нийцлийн асуудлаар нийт 228.0 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 160.5 тэрбум төгрөгийн 34 зөрчилд албан шаардлага,

12.7 тэрбум төгрөгийн 3 зөрчилд 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 54.7 тэрбум төгрөгийн зөрчилд 19 зөвлөмж өглөө.



ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Засгийн газрын 22 тусгай сангаас 20 тусгай сан аудитад хамрагдаж, тайлант онд 2 тусгай сан үйл ажиллагаа эхлээгүй тул аудитад хамрагдаагүй. Аудитад хамрагдсан 20 тусгай сангаас 11 тусгай сангийн санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаж, 9 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Боловсролын зээлийн сан, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Шинжлэх ухаан, технологийн сан, Эрүүл мэндийг дэмжих санд “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө. Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 5.8 тэрбум төгрөгийн 19 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын түвшинд нийт 256.7 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.3 тэрбум төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 181.4 тэрбум төгрөгийн зөрчилд 43 албан шаардлага, 22.7 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 7 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 5 санал хүргүүлж, 51.6 тэрбум төгрөгийн зөрчилд 27 зөвлөмж өгч, 0.7 тэрбум төгрөгийн 3 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүллээ.

Мөн холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн нийцлийн асуудлаар нийт 2.3 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс, 1.5 тэрбум төгрөгийн зөрчилд 18 албан шаардлага, 0.8 тэрбум төгрөгийн зөрчилд 13 зөвлөмж өглөө.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдад 4, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 2, Сангийн сайдад 4 зөвлөмжийг хүргүүлсэн.



Улсын Их Хурлын анхааралд толилуулсан асуудал:

Тухайн жилийн төсвийн тухай хуулиар батлаагүй хөрөнгө оруулалтын болон нийгмийн шинж чанартай төсөл арга хэмжээг төрийн өмчит хуулийн этгээдүүд нийгмийн хариуцлагын хүрээнд санхүүжүүлж байгаа нь байгууллагын ашигт ажиллагаа, төвлөрүүлэх ногдол ашигт нөлөөлж байгаа асуудлыг анхаарч хуулийн тодорхой зохицуулалттай болох;

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарьт орсон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар дэмжлэг үзүүлэх;

Монгол Улсын Их хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор 25 төрийн өмчит хуулийн этгээдийг нэмж хувьцаа гарган биржээр нээлттэй арилжаалах замаар олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангахыг Засгийн газарт үүрэг болгосон боловч хэрэгжилтийг хангуулахыг уламжилж байна.

МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1^{*}-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2^{**} дахь заалтын дагуу аудит хийсэн. Аудитын зорилтыг Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн зорилт үр нөлөөтэй хэрэгжсэн, төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг УИХ-д танилцуулахад чиглүүлж, нийт 3611 төсөвт байгууллага, сангуудын төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитад хамрууллаа.

Дүрслэл 1. Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн байгууллагын тоо

УТЕЗ	ОНТЕЗ	НДС	ЭМДС	МУНТГ
38* 1,232**	22* 2,340**	1* 36**	1* 3**	62* 3,611**

Тайлбар:

* Төсвийн ерөнхийлөн захирагч

** Төсвийн байгууллага, төсвийн гүйцэтгэлийн тайлан

*** Гүйцэтгэлээр санхүүжих байгууллага-2,496

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгсөн байна.Тухайлбал;

- Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн өмнөх оноос 36.0 хувиар өсөж 23,294.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 24.0 хувиар өсөж 22,509.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 785.9 тэрбум төгрөгийн ашигтай буюу эерэг үзүүлэлттэй байна.
- Төсвийн тухай хуулийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай бүрд Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуулийг өөрчилж байгаа нь эдийн засгийн үзүүлэлтүүдийг урьдчилан тооцсон төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна.
- Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсөв нь төсвийн бодлогын зорилт, Улсын Хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн боловч улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар санхүүжих төсөл, арга хэмжээг төсөвт бүрэн тусгаагүй байна.
- Уул уурхайн салбараас хэт хамааралтай төсвийн тэлэлт нь эрдэс баялгийн бүтээгдэхүүний эрэлт, зах зээлийн үнэ буурснаар төсвийн орлого тасалдах, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах эрсдэлийг бий болгож байна.
- Татварын бус орлого тасарсан нь гадаад тусламжаар хэрэгжих зарим төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, навигаци, газрын тосны бүтээгдэхүүний орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүйтэй холбоотой байна.
- Төсвийн нийт зарлага тэлж байгаа ч нийгэм эдийн засагт үр өгөөж бий болгох нэмүү өртөг шингэсэн, бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэхгүй байна.


^{*} Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ.

^{**}Төрийн аудитын төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэг сарын дотор аудит хийж, Засгийн газар, Улсын Их Хуралд хүргүүлэх

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээнд батлагдсан санхүүжилтээс гүйцэтгэгчид 260.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, хөрөнгийн зардлын санхүүжилтийг 76.5 тэрбум төгрөгөөр бууруулан тайлагнасан байна.
- Эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, аргачлалыг бодитой тодорхойлоогүйгээс сангийн эх үүсвэр хүрэлцэхгүй, 218.3 тэрбум төгрөгийн өртэй байна.
- Нийгмийн даатгалын сангийн 162.9 тэрбум төгрөгийн түргэн хөрвөх хөрөнгө эрсдэлтэй, Капитал банкны эрх хүлээн авагчаас хүлээн авсан 15.9 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг борлуулж, түргэн хөрвөх хөрөнгөнд шилжүүлэх ажил удаашралтай байна;

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг аудитаар хянахад Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд 65.4 хувь, Сангийн сайд 80.7 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

Зөвлөмжийн хэрэгжилт /тоо, хувиар/



Нийт 17 зөвлөмжөөс бүрэн биелсэн 3, хэрэгжих шатандаа 11, хэрэгжүүлээгүй 3, нийт зөвлөмжийн биелэлт 60.9 хувьтай, төсвийн сахилга бат хангалтгүй байна.

Өмнөх оны аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдад өгсөн 2, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны даргад өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөвлөмжийг хүргүүлсэн байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайдад:

- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн төсөл, арга хэмжээнд тавих шаардлагыг Төсвийн тухай хуулийн шаардлагатай нийцүүлж, Улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан улсын төсөв, гадаадын зээл тусламжийн эх үүсвэрээр санхүүжих төсөл арга, хэмжээг тухайн жилийн төсөвт бүрэн тусгуулах;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан зарим арга хэмжээний холбогдох дүрэм журмыг боловсруулж батлуулах;
- Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг хэрэгжүүлж, шийдвэрийн биелэлтийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар хянаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад:

- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж байгаа төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийн хариуцах эзэн, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг бодитой төлөвлөж, хуулийн шаардлагыг хангасан төлөвлөгөөг батлуулах.

Сангийн сайдад:

- Төсвийн орлого уул уурхайн салбараас хэт хамааралтай, эрсдэл бүхий байгаа тул цаашид санхүүгийн хуримтлалыг тогтвортойгоор үүсгэж, үр дүнтэй удирдах;
- Татварын бус орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж, орлогын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах;
- Төсвийн зардлын хэмжээ болон бүтцийг тодорхойлохдоо богино хугацааны макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, урт хугацааны үр ашгийг нэмэгдүүлэх зарчмыг баримтлах, төсвийн ачааллыг дунд, урт хугацаанд бууруулах бодлого баримтлан ажиллах;
- Дотоодын зах зээлд Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг иргэд, аж ахуйн нэгжид зориулан хөгжүүлж, Засгийн газрын өрийн дүнд эзлэх гадаад өрийг үе шаттайгаар бууруулах;
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг төсвийн гүйцэтгэлийн тайланд бүрэн тайлагнаж, төлөвлөгөөнөөс давж биелсэн орлогын зарцуулах эрхийг төсвийн дараагийн жилд олгож, зарцуулалтыг төсвийн гүйцэтгэлд тайлагнадаг байхаар журамд өөрчлөлт оруулах;
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг төсвийн үйл ажиллагаанд ашигладаг системүүдтэй мэдээлэл солилцох, байршуулах боломжийг бүрэн бүрдүүлж, хяналтыг сайжруулах;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын эх үүсвэртэй уялдуулж, даатгалын сангаас санхүүжих эмнэлгийн тусламж үйлчилгээний төрөлд дүн шинжилгээ хийж, оновчтой болгох;
- Нийгмийн даатгалын сангийн Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 68.2 тэрбум төгрөгийн авлага, Чингис хаан банканд байршиж буй 94.9 тэрбум төгрөгийн сангийн хөрөнгийн эрсдэлийг бууруулах.

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдад 3, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 1, Сангийн сайдад 8 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.



“ ————— Улсын Их Хурлын анхааралд толилуулсан асуудал: ————— ”

Засгийн газраас тайлагнасан Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн дүн 23,294.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 22,509.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг аудитаар баталгаажууллаа.


Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуульд тусгасан эдийн засгийн үзүүлэлтүүдийг тухайн жилийн төсвийг батлахдаа өөрчлөлт оруулж байгаад анхаарал хандуулахыг толилуулж байна.

МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН АУДИТЫН ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7 дахь заалт болон Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын Хорооны 2023 оны Аудитын сэдэв батлах 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аудитыг гүйцэтгэж, дүгнэлтийг Улсын Их хурал болон холбогдох байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлээ.

Аудитаар Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцсэн ба Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагуудыг хангасан боловч Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026–2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг төсөвт өөрчлөлт оруулах бүрд нэмж өөрчилж байгаа нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байгааг онцолсон.

Төрийн аудитын байгууллагаас Улсын болон орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитаар орлого нэмэгдүүлэх 75 асуудал бүхий 39.6 тэрбум төгрөг, зардал бууруулах 143 асуудлаар 78.5 тэрбум төгрөг, үр ашгийг дээшлүүлэх 118 асуудлаар 84.9 тэрбум төгрөгийн саналыг тус тус боловсруулан хүргүүлж УИХ болон орон нутгийн ИТХ-аар хэлэлцүүлээ.



Улсын Их Хурлын анхааралд толилуулсан асуудал:

Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, төсвийн ил тод байдлыг хангах зарчмын хүрээнд төсөвлөлтийн шаардлага хангаагүй, Төрийн хэмнэлтийн хуулийн холбогдох заалтад нийцээгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөвт тусгахгүй байх.

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь хэсэг, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолд тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллагын хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэв.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд 21 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тухайн оноос эхлэн хэрэгжих 10, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 1,129, нийт 7,376.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1,139 төсөл, арга хэмжээг 2,686.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь өмнөх онтой харьцуулахад 51.9 хувиар өссөн байна.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийсэн байна. Тухайлбал:

- Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тухайн жилийн 2,686.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэл 83.2 хувь, тухайн онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн 883 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 62.5 хувьтай байна.
- Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах, санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулж төлөвлөхгүй байгаа зэрэг нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх шалтгаан болж байна.
- Төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардлын үндэслэл, тооцоололд тавих Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хяналт хангалтгүй байгаад дотоод аудит хийж, үр дүнг тооцох шаардлагатай байна.
- Барилга байгууламжийн ажилд үе шатны хяналт гүйцэтгэж байгаа байгууллагуудын хүний нөөцийн хүрэлцээ, мэргэжлийн чадавхад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж захиалагчийн хяналтын чанар, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тулгарсан асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг, хариуцах байгууллага, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа, шат дараалал тодорхойгүй, гэрээний хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, зогсонги байдалд хүргэхэд нөлөөлж байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, тэргүүлэх ач холбогдол, эдийн засгийн үр өгөөжөөр нь эрэмбэлж төлөвлөхгүй, санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой ашиглахгүй байна.

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлээ. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайд:

- Барилга байгууламжийн ажлын үе шат бүрийг хянах үйл ажиллагаа, захиалагчийн хяналтын тогтолцооны үр нөлөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын эрх үүрэг, хоорондын харилцааг зохицуулах, тулгарсан асуудлыг шийдвэрлэх, гэрээ цуцлах, хохирлыг тооцож нэхэмжлэх, гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааг төвлөрүүлэхтэй холбоотой зохицуулалтыг холбогдох журамд нэмж тусгах.

Монгол Улсын Шадар сайд Бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан боловч гадна шугам сүлжээ, эх үүсвэрийг иж бүрэн төлөвлөөгүйгээс зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй барилга байгууламж, тоног төхөөрөмжийн санхүүгийн болон бусад эх үүсвэрийг шийдвэрлэх замаар хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх;
- Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлын даалгаварт тавигдах шаардлага, хүлээн авах шалгуур, төсөвт өртгийг тооцох жишиг үнийг тогтоож мөрдүүлэх.

Сангийн сайдад:

- Худалдан авах ажиллагаанд давуу эрх тооцуулан шалгарсан тохиолдолд түүнд хяналт тавих, хэрэгжилтийг үнэлэх, хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтыг холбогдох заавар, журамд тусгах;
- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд Төсвийн ерөнхийлөн захирагч бүр төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн мэдээллийг бүрэн байршуулсан эсэхэд хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хийх.
- Төсвийн Ерөнхийлөн захирагчдад:
- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд төсөл, арга хэмжээний төлөвлөлт, багцын задаргаа, хэрэгжилт, санхүүжилтийн мэдээллийг бүрэн байршуулах, бүрэн байршуулсан эсэхэд хагас жил тутам дотоод аудит хийж хэрэгжилтийг хянах.

Барилга, хот байгуулалтын сайдад:

- Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн чиглэл, арга зүйгээр хангах;
- Барилга байгууламжийн зураг төсөл, ажлын чанар, гүйцэтгэлд илэрч байгаа нийтлэг зөрчил, тулгарч байгаа асуудалд судалгаа, шинжилгээ хийж барилгын норм, дүрэм, стандартыг өөрчлөн шинэчлэх, сайжруулах ажлыг зохион байгуулан, норм нормативын сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулах.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон үйлдвэр, агуулах, зоорь, хүлэмж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, үржлийн мал зэргийн ашиглагчийг нээлттэй, ил тод, өрсөлдөөнт зарчмаар сонгон шалгаруулах, оновчтой, үр ашигтай ашиглахад чиглэсэн журам, заавар боловсруулан баталж, нэгдсэн арга зүйгээр хангах, хэрэгжилт үр дүнг бүртгэх, тайлагнах, хянах, хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлэх.

Боловсрол, шинжлэх ухааны сайдад:

- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ширээ, сандалд тавигдах чанар, эдэлгээтэй холбоотой нарийвчилсан шаардлагыг боловсруулан мөрдүүлэх, бүсчилсэн хэлбэрээр орон нутагт үйлдвэрлэх, нийлүүлэх нөөц боломжийг судалж худалдан авах ажиллагааг чанартай, үр ашигтай, хэмнэлттэй байхаар зохион байгуулах.

Түүнчлэн Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрууд тухайн орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, тайлан дүгнэлтийг баталгаажуулан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэн хэлэлцүүлж, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Сангийн сайдад 4, Барилга хот байгуулалтын сайдад 2, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад 1, Боловсрол, шинжлэх ухааны сайдад 1 зөвлөмжийг хүргүүлээ.



УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/152 дугаар тушаалыг үндэслэн "Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудит хийлээ. Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийлээ. Үүнд:

- Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөө 70.8 хувьтай хэрэгжсэн бөгөөд нийт төсөл, арга хэмжээний 28.4 хувь нь "Үр дүнтэй", 38.8 хувь нь "Тодорхой үр дүнд хүрсэн", 24.4 хувь нь "Эрчимжүүлэх шаардлагатай", 8.5 хувь нь "Үр дүнгүй" байна.
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Төсвийн тухай хуульд заасан төсөл, арга хэмжээнд тавих шаардлага ялгаатай байгаа нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө тухайн жилийн төсвийн тухай хуультай уялдахгүй байхад ихээхэн нөлөөлж байна.
- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний суурь түвшин, шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн эх үүсвэр, санхүүжилтийн хэмжээг бодитой тодорхойлоогүйгээс төлөвлөсөн төсөл, арга хэмжээ зорилтот түвшинд хүрэхгүй, улмаар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг бууруулж байна.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээс санал авах, иргэд, олон нийтээр хэлэлцүүлэх асуудал хангалтгүй, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан арга хэмжээг тусгахад чиглэсэн бодлого баримталж байгаа нь "Төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчим"-ыг алдагдуулж байна.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан 201 төсөл, арга хэмжээнээс



Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 2, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн Засгийн хөгжлийн сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нарт 2, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд нарт 1, Төсвийн ерөнхийлөн захирагч нарт 2 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

“**Улсын Их Хурлын анхааралд толилуулсан асуудал:**

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2- т "... Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн ..., Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасныг тус тус баримтлан батлах" гэж заасан бүрэн эрхийн дагуу тухайн жилийн төсвийн тухай хуулийг батлахдаа Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулахад анхаарал хандуулахыг толилуулж байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрх, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолоор баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын сэдэв”, МҮЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн гүйцэтгэв.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 бодлого, 23 зорилго, 261 зорилт бүхий 1046 арга хэмжээний 2021-2023 оны хэрэгжилтэд аудит хийхэд хөтөлбөрт оролцогч талуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, арга хэмжээнд шаардлагатай төсөв хөрөнгө нь батлагдаагүйгээс тухайн зорилт, арга хэмжээний хэрэгжилт зорилтот үр дүнд хүрээгүй, хөтөлбөр 70.5 хувийн биелэлттэй байна.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 бодлогын 2021-2023 оны хэрэгжилтийг авч үзэхэд “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого 83, Хүний хөгжлийн бодлого 67, Эдийн засгийн бодлого 59, Засаглалын бодлого 74, Ногоон хөгжлийн бодлого 67, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого 73 хувийн тус тус биелэлттэй байна.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2021-2023 онд Улсын төсөв, гадаадын зээл тусламж, Засгийн газрын тусгай сан, хувийн хөрөнгө оруулалт, хандив, тусламж зэрэг санхүүгийн эх үүсвэрээр 835 арга хэмжээг нийт 89,262.8 тэрбум төгрөг шаардлагатай гэж төлөвлөснөөс мөн онуудад 728 арга хэмжээнд нийт 34,803.2 тэрбум төгрөгийн хөрөнгийг зарцуулсан ч эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй арга хэмжээ 396 буюу 37.9 хувийг эзэлж байна.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 154 шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 61 шалгуур үзүүлэлт уялдаж хэрэгжсэнээс 2021-2023 оны үр дүнгээр 17 шалгуур үзүүлэлтийн үр дүн нь хангагдаж 27.9 хувийн хэрэгжилттэй байна.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшингийн 2021-2023 оны хүрсэн түвшний нэгтгэл.

Бодлогын дугаар	Бодлогын нэр	Зорилтод тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо	2021-2023 онд хүрсэн түвшин	
				хүрсэн	хүрээгүй
Хоёр	Хүний хөгжлийн бодлого	6	44	20	23
Гурав	Эдийн засгийн бодлого	7	52	31	21
Дөрөв	Засаглалын бодлого	6	30	15	15
Тав	Ногоон хөгжлийн бодлого	1	14	6	8
Зургаа	Нийслэлийн ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	2	13	8	5
	Нийт дүн	23	153	80	72

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайдад 4, Төсвийн ерөнхийлөн захирагчид болон хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагад 3 зөвлөмжийг хүргүүлсэн.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬТАЙ ХОЛБОГДУУЛАН ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу нэр дэвшигч, нам, эвслийн зардлын дээд хэмжээг тогтоох, мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах, хандивын тайлан, сонгуулийн зардлын тайланг баталгаажуулах аудитыг гүйцэтгэлээ. Төрийн аудитын байгууллага Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулиар дараах асуудалд аудит хийж дүгнэлт гаргах чиг үүргийг хүлээсэн. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д заасны дагуу нам, эвсэл болон тойрогт нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө аргачлалын дагуу тогтоож, нийтэд мэдээлэх;
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.13-т заасны дагуу нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааг хамаарсан хандивын тайланд дүгнэлт гаргах;
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.10-т заасны дагуу нам, эвслийн мөрийн хөтөлбөрт хийсэн дүгнэлтийг санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлэх, сонгуулийн зардлын тайлангаа хүргүүлэх өдрийг дуустал өөрийн байгууллагын цахим хуудаст нээлттэйгээр байршуулах;
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хурлын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1-т заасны дагуу сонгуулийн зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлэх;
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8-д заасан зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд төрийн аудитын байгууллага хяналт тавин, аудит хийж, дүгнэлт гаргах.

Төрийн аудитын байгууллага Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиар дараах асуудалд аудит хийж дүгнэлт гаргах чиг үүргийг хүлээсэн. Үүнд:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1⁶;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.10⁷, 37.11⁸;

⁶ 49.1 "хуульд нийцүүлэн төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага тухайн аймаг, сум, нийслэл, дүүрэг дэх сонгуулийн тойрогт нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг ээлжит сонгуулийн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө тогтоож, нийтэд мэдээлнэ."

⁷ 37.10 "Төрийн аудитын байгууллага нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр энэ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлтийг санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө гаргаж, тухайн шатны сонгуулийн хороонд хүргүүлнэ."

⁸ 37.11 "Төрийн аудитын байгууллага бие даан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр энэ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлтийг санал авах өдрөөс 35-аас доошгүй хоногийн өмнө гаргаж, тухайн шатны сонгуулийн хороонд хүргүүлнэ"

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.12⁹;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.11¹⁰;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1¹¹.

Сонгуулийн өмнөх нэг жилийн хугацаанд тухайн сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд нэгдэн орсон намуудад иргэд, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулах

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан хугацаанд 30 нам, 11 бие даан нэр дэвшигч нийт 41 хандивын тайланд дүгнэлт гаргуулахаар ирүүлснийг хандив өгсөн хуулийн этгээд болон хандивын эх үүсвэр бүрээр тулган баталгаажуулалт хийж аудитын горим сорил хэрэгжүүлэн ажилласан.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай 38 дугаар зүйлийн 38.10-т заасан хугацаанд Сонгуулийн Ерөнхий Хороонд Нам, эвслийн хандивын тайлангийн дүгнэлт, мөн бие даан нэр дэвшигчийн хандивын тайланг нэр дэвшигч нарт хүлээлгэн өгч ажилласан байна.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрууд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн өмнөх нэг жилийн хугацаанд тухайн сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд нэгдэн орсон намуудад иргэд, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, аудитын дүгнэлтийг 2024.09.18-09.25-ны өдрүүдэд олон нийтэд мэдээлсэн.

⁹ 37.12 "Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага нь энэ хуульд заасан нам, эвслийн хандивын тайлан, сонгуулийн мөрийн хөтөлбөр болон түүнд хийсэн дүгнэлтийг санал авах өдрөөс 22 хоногийн өмнөөс эхлэн энэ хуульд заасны дагуу нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа хүргүүлэх өдрийг дуустал өөрийн байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт нээлттэйгээр байршуулна."

¹⁰ 10.11 "Аймаг, нийслэлийн Хурлын сонгуулийн хороодын тайланд тухайн орон нутаг дахь төрийн аудитын салбар байгууллагаар дүгнэлт гаргуулна"

¹¹ 57.1 "Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ"



Сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоох

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар 50.1-т заасны дагуу 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр сонгуульд нам эвсэл, тойрогт нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтон нийтэд мэдээлж, хуулийн хугацаанд Сонгуулийн Ерөнхий хороонд хүргүүлсэн.

Сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоосон дүн мэдээг Eagle TV болон Тэнгэр TV, NTV, mass.mn, Tug.mn-д ярилцлага өгч, байгууллагын болон Сонгуулийн ерөнхий хорооны албан ёсны цахим сайтаар олон нийтэд ил тод, нээлттэй мэдээллээ.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрууд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах хөрөнгийн дээд хэмжээ тогтоох аудитыг гүйцэтгэж, сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоож, 2024.06.25-29-ний өдөр олон нийтэд мэдээлээ.

Сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, намуудын эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт арга хэмжээг хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргах

Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл болон 27 нам, 2 эвсэл УИХ-ын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр ирүүлсэнд хяналт тавьж, нам, эвслээс хуульд заасан хугацааны дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн мөрийн хөтөлбөрт аудит хийж зөрчлийг арилгуулан хуульд заасан шаардлагад нийцсэн тухай дүгнэлт гарган Сонгуулийн ерөнхий хороонд 2024.04.25-ны өдөр хүргүүллээ.

УИХ-ын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч 77 иргэн мөрийн хөтөлбөрийг хүлээн авч хууль тогтоомжид нийцсэн эсэхийг хянан 8 иргэний мөрийн хөтөлбөр хуульд нийцээгүй тул буцааж алдаа зөрчлийг засварлан дахин ирүүлэхийг зөвлөж буцаан засварлуулж 2024.05.14-ний өдөр хүлээн авч дахин хянан баталгаажуулж нийт 75 бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг 2024.05.24-ний өдөр Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэн ажилласан байна.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрууд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу орон нутгийн сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, намуудын эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт арга хэмжээг хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд аудит хийж, аудитын дүгнэлтийг 2024.09.18-09.25-ны өдөр олон нийтэд мэдээлсэн.

Сонгуульд оролцсон нам, эвсэл, гишүүнд нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, түүний гүйцэтгэлийг нэгтгэн үр дүнг олон нийтэд мэдээлэх

Төрийн аудитын байгууллага Улсын Их Хурлын сонгуульд оролцсон нэр дэвшигчид болон нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нэр дэвшигчидэд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн нийт 7989 иргэний 50.3 тэрбум төгрөгийн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн 762 хуулийн этгээдийн 18.3 тэрбум төгрөгийн хандивын мэдээллийг тус тус нэгтгэн, нам, эвсэлд нийт давхардсан тоогоор нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн нийт 509 иргэний 8.7 тэрбум төгрөгийн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн 126 хуулийн этгээдийн 3.3 тэрбум төгрөгийн хандивын мэдээллийг тус тус нэгтгэн audit.mn цахим хуудсаар 2024.09.26-ны өдөр олон нийтэд ил тод мэдээлсэн.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрууд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-д заасны дагуу нам, нэр дэвшигчдийн зардлын дансны мэдээлэл, 56 дугаар зүйлийн 56.3-д заасны дагуу нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хүлээн авч 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт зааснаар зардлын тайланг баталгаажуулах аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын тайланг баталгаажуулан 2024.12.30-ны өдрийн дотор аймгийн сонгуулийн хороодод хүргүүлж, мөн хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д заасны дагуу хандив өгсөн иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг байгууллагын мэдээллийн самбар болон вэб сайт, пейж хуудсаар нийтэд ил тод мэдээлсэн байна.

Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8-д заасны дагуу Улсын Их хурлын сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, тайлан дүгнэлтийг МҮЕА-ын 2024.12.09-ний өдрийн А/94 дугаартай тушаалаар баталгаажуулж, Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлсэн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.11-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагууд орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргаж тайланг аймаг, нийслэлийн Сонгуулийн хороонд хүргүүллээ.

ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГЭЭР ХАЙГУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ГЭРЭЭЛЭГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХСӨН БОЛОН НӨХӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТООЦОО, ХУВААРИЛАЛТАД БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙСЭН АУДИТ

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн 2020-2021 оны нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг баталгаажуулах аудитын тайланг МҮЕА-ын 2023.12.19-ний А/164 дүгээр тушаалаар баталгаажуулсан. Аудитаар нийт 7.5 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлснээс 7.5 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоож, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар холбогдох байгууллагуудад 11 зөвлөмж өгсөн.

Хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа 6 гэрээлэгчийн 2022-2023 оны нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг баталгаажуулах аудитыг гүйцэтгэн цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн 5 дүгнэлт, 8 зөвлөмж, 2 төлбөрийн акт, 2 албан шаардлага өгсөн. Аудитын тайланг МҮЕА-ын 2024.12.31-ний өдрийн А/116 дугаар тушаалаар баталгаажуулж шалгагдагч байгууллага болон УИХ-ын холбогдох байнгын хороонд хүргүүлээд байна.



ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГЭЭР ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ГЭРЭЭЛЭГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХӨГДСӨН БОЛОН НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТООЦОО, ХУВААРИЛАЛТАД БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙСЭН АУДИТ

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2019-2021 оны нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг баталгаажуулах аудитын тайланг МҮЕА-ын 2023.12.26-ны өдрийн А/168 дугаар тушаалаар баталгаажуулсан. Аудитаар 2 албан шаардлага, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлагыг тус тус хүргүүлж, нийт үнийн дүнгээр гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй үйлдлүүдийг шалгуулахаар прокурорын байгууллагад шилжүүлсэн.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй 3 гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардлын тайланд Ашигт малтмал, газрын тосны газраас хяналт шалгалт хийж, тайлан дүгнэлтийг Төрийн аудитын байгууллагад ирүүлснээр баталгаажуулах аудитыг гүйцэтгэн цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн 5 дүгнэлт, 7 зөвлөмж, 2 төлбөрийн акт өгч, аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024.12.31-ний өдрийн А/117 дугаар тушаалаар баталгаажуулж, шалгагдагч байгууллага болон холбогдох Байнгын хороонд хүргүүлсэн.



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөөнд аудит хийж, дүгнэлт гаргахад аудитын зорилго чиглэж тайланг УИХ болон албан тушаалтанд танилцуулж, мэдээлэн, тогтолцоог сайжруулах санал, зөвлөмжийг Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, холбогдох албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитад Төрийн албаны зөвлөл болон Төрийн албаны тухай хуулиар тодорхойлсон төрийн улс төрийн, төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаалтнуудыг ажиллуулж байгаа төрийн байгууллагууд болох яамд, түүний харьяа байгууллагууд, тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, салбар нэгж, нутгийн өөрөө удирдах байгууллагуудын үйл ажиллагааг хамруулав.

Төрийн албаны хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, эрх зүйн зохицуулалт, сайжруулалт хийж буй эх өгөгдлийн иж бүрдэл, мэдээллийн бодит байдал хангалтгүйгээс хэрэгжилтийг хангах тогтолцоо бүрдээгүй байна.

Төрийн албаны хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцооны цахим системд албан хаагчийн мэдээлэл давхардсан, “ангилалгүй” гэх хуульд заагаагүй төрлөөр бүртгэсэн, ажилласан жил алдаатай илэрхийлэгдсэн зэргээр мэдээллийн үнэн зөв байдлыг үнэлэх, баталгаажуулах боломжгүй, цахим системийг ашиглан хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, бодлогын шийдвэр гаргах боломжгүй, төрийн байгууллагуудын сул орон тооны мэдээллийг цаг хугацаанд нь авч чадахгүйгээс сонгон шалгаруулалтад оролцох, шатлан дэвших боломжоо илэрхийлэх нөхцөлийг хааж, өрсөлдөөнийг хязгаарласан шинжтэй, төрийн албан хаагчийг гүйцэтгэлд суурилсан сургалтад хамруулахаар төлөвлөх боломжгүйд хүргэсэн байна.

Төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэвийг хууль тогтоомжоор тогтоохоор заасан, мөн эдгээр байгууллагын хүний нөөц, цалин хөлсний мэдээлэл нь тодорхойгүй, төрийн зарим тусгай албаны ангилал, зэрэглэлийг цалингийн шатлалд дүйцүүлэх шийдвэрүүд эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгэгдээгүй байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Засгийн газарт 4, Төрийн албаны зөвлөлд 3, нийт 7 зөвлөмжийг хүргүүлсэн.



Улсын Их Хурлын анхааралд толилуулсан асуудал:

Нийт төрийн албан хаагчийн 97.0 орчим хувь нь Засгийн газрын харьяа байгууллагын албан хаагчид байгаа өнөөгийн нөхцөлд Засгийн газар урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтоо хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцөө бүрдүүлэх, тэдгээртэй холбоотой шийдвэр гаргахад Төрийн албаны зөвлөлийн чиг үүрэг, гүйцэтгэх засаглалын чиг холилдсон байгаад анхаарч, Төрийн албаны зөвлөл нь Төрийн албаны тухай хуулийн дагуу хүний нөөцийн удирдлагыг хэрхэн хэрэгжүүлж буйд хөндлөнгийн хяналт тавих чиглэлээр, харин Засгийн газар урт хугацааны бодлогыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх чадавх бүрдүүлэх чиглэлд ажиллах байдлаар чиг үүргийг салгах нь зүйтэй байна.

Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд тодорхой урамшууллыг улирал тутамд олгохоор заасан нь улсын төсөвт жил бүр 47.6 тэрбум, 5 жилд 238.1 тэрбум төгрөгийн ачаалал үүсгэхээр байх тул ёс зүйн харилцааг зохицуулах өөр үр дүнтэй арга замыг сонгон хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулах.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсад нийгмийн даатгалын талаар баримталж байгаа бодлогыг хэрэгжүүлэх үр нөлөөтэй, оновчтой тогтолцоо бүрдсэн эсэх, даатгуулагчийн санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж иргэдийн амьдралын баталгаа алдагдаж орлогын эх үүсвэргүй болох аливаа эрсдэлийг нийгмийн даатгалын дэмжлэгтэйгээр бууруулах баталгаагаар хангагдах боломж бүрдсэн эсэхэд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Нийгмийн даатгалын асуудлаар "Амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх" урт хугацааны зорилт тавьсан ч дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээтэй нийцээгүй, уг зорилтод бүрэн чиглээгүй, голчлон тэтгэврийн шинэчлэл хийх үйл явцад чиглэсэн байна.



Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг удирдах зохистой бодлого, удирдлага байхгүй, чөлөөт мөнгөн үлдэгдлийг арилжааны банканд байршуулахдаа Монгол банкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг харгалзан үзээгүйгээс 150.0 тэрбум төгрөгийг банкнуудын дампуурлаас алдсан, Чингисхаан банканд байршуулсан 126.9 тэрбум төгрөгийн авлага хүлээлтийн байдалтай, Монгол банкны бодлогын хүүгээс бага хувиар байршуулснаас 12.2 тэрбум төгрөг, хадгаламж хэлбэрээр байршуулаагүйгээс 215.8 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олох боломж алдсан, бусад санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах зохицуулалтыг хийгээгүй байна.

Эдгээрээс үүдэж сангийн үйл ажиллагаа эрсдэлтэй нөхцөлд орж, даатгуулагчдын санхүүгийн ирээдүйн эрсдэлийг хуваалцах боломжгүй байдалд хүрсэн байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Эрүүл мэндийн яаманд 2, Нийгмийн даатгалын ерөнхий газар 7, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 2, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 2 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.



“————— Улсын Их Хурлын анхааралд толилуулсан асуудал: —————”

Нийгмийн даатгалын асуудлаар шийдвэр гаргахдаа бусад салбарын хуулиудын уялдаа болон нийгмийн даатгалын санд үзүүлэх нөлөөллийн тооцоолол, хүндрэлийг харгалзан үзэж, шаардлагатай санхүүжилтийг бүрэн шийдвэрлэх;

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг Нийгмийн даатгалын ерөнхий хуультай уялдуулан өөрчлөлт хийн баталж, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн эрх зүйн чадамжийн талаарх асуудлыг шийдвэрлэх.